

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын Хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/558/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 7007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр Утас: 325093 Цахим хаяг: Munkhdelgerd@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn</p>
[OBJ/OBJ]	[OBJ/OBJ]

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
5. Дараагийн аудитаар анхаарах асуудал:	13
6. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 148
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХСАЙХАН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлан жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар худалдан авах ажиллагааг төсөвт өртгийн дээд хэмжээнээс хэтрүүлсэн, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэсэн, холбогдох эрх зүйн актын дагуу урамшуулал олгоогүй, нийт 224.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3.3-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

C:\Users\narangua\Desktop\Бичиг хэрэг\2026\2026\word\audit\2026\02\25\02250148.docx 1426050791

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд дүүргийн ИТХ-аас 238.5 сая төгрөг, ЗДТГ-аас 84.4 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 120.8 сая төгрөг, нийт 443.7 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 437.6 сая төгрөг зарцуулж, 6.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд дүүргийн хөрөнгө оруулалтаар 293.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, дээд шатны төсөв захирагчаас 1,594.7 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр олгосон байна.

Бусад асуудал

Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу алслагдсан 21 дүгээр хороо "Жаргалант" тосгонд байрлах 6.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Гал түймэр унтраах, аврах 82 дугаар ангийг байгуулахаар 1.1 га газрын гэрчилгээ, ажлын зураг, А даалгаврыг гаргуулан, 2025 оны 06 дугаар сард барилгын шав тавих ёслолын арга хэмжээг зохион байгуулсан байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		<u>2,314,827,670.82</u>	<u>2,683,966,251.73</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6	2,302,546,796.82	2,683,966,251.73
351	Түүхий эд материал		1,206,635,923.22	1,791,224,864.35
35110	Тусгай зориулалттай материал		1,206,560,923.22	1,791,224,864.35
354	Хангамжийн материал		527,824,657.70	892,741,387.38
35410	Бичиг хэргийн материал		40,949,720.00	58,225,430.00
35420	Аж ахуйн материал		41,844,848.00	83,320,356.00
35430	Сэлбэг хэрэгсэл		50,641,581.00	40,227,417.00
35450	Барилгын засварын материал		3,165,300.00	3,631,300.00
35460	Хүнсний материал		00.00	10,440,000.00
35470	Бусад хангамжийн материал		375,310,941.46	696,896,884.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		<u>7,073,989,898.17</u>	<u>6,333,942,120.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	7,073,989,898.17	6,333,942,120.98
392	Биет хөрөнгө		6,621,290,817.58	5,881,243,040.39
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,476,156,801.74	1,476,156,801.74
39202	Хуримтлагдсан элэгдэл		-458,897,873.78	-505,519,656.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл		9,755,962,468.94	10,049,862,468.94
39204	Хуримтлагдсан элэгдэл		-4,770,446,896.85	-5,683,774,031.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		991,367,498.48	1,036,467,498.48
39206	Хуримтлагдсан элэгдэл		-432,079,459.12	-544,613,088.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		56,060,074.00	56,060,074.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		-14,947,209.49	-19,772,113.45
39214	Бусад үндсэн хөрөнгө		21,948,000.00	21,948,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-3,832,586.34	-5,572,913.22
393	Биет бус хөрөнгө		452,699,080.59	452,699,080.59
39301	Програм хангамж		1,080,000.00	1,080,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-1,080,000.00	-1,080,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		<u>9,388,817,568.99</u>	<u>9,017,908,372.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		00.00	1,284,040.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		00.00	1,284,040.00
413	Өглөг	9	00.00	1,284,040.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		00.00	1,284,040.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		<u>9,388,817,568.99</u>	<u>9,016,624,332.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		9,388,817,568.99	9,016,624,332.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,405,067,222.28	1,405,067,222.28
51101	Өмч: - төрийн		1,405,067,222.28	1,405,067,222.28
512	Хуримтлагдсан үр дүн		7,157,084,872.87	6,784,891,636.59
51210	Өмнөх үеийн үр дүн		7,157,084,872.87	7,157,084,872.87
51220	Тайлант үеийн үр дүн		00.00	-372,193,236.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		826,665,473.84	826,665,473.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		<u>9,388,817,568.99</u>	<u>9,017,908,372.71</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	5,552,116,948.65	6,945,865,842.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,433,443,534.25	1,933,682,329.23
120	Нийтлэг татварын бус орлого		1,433,443,534.25	1,933,682,329.23
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө		86,454,000.00	339,000,000.00
120004	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал		1,346,989,534.25	1,594,682,329.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,118,673,414.40	5,012,183,513.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		3,892,071,700.00	4,568,526,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		3,892,071,700.00	4,568,526,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		226,601,714.40	443,657,013.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		26,857,420.00	49,954,020.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		53,062,000.00	50,828,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		146,682,294.40	342,874,993.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	5,243,533,323.69	7,318,059,078.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,243,533,323.69	7,318,059,078.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,209,769,431.07	7,299,911,501.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,437,353,128.15	4,067,812,100.00
210101	Үндсэн цалин		2,238,543,368.15	2,512,767,700.00
210102	Нэмэгдэл		995,054,660.00	1,373,492,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		25,646,500.00	23,473,400.00
210104	Урамшуулал		178,108,600.00	158,078,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		74,703,300.00	98,116,300.00
210201	Тэтгэврийн даатгал		4,489,400.00	9,094,200.00
210202	Тэтгэмжийн даатгал		725,757.60	551,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		412,913.92	282,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал		312,843.68	5,170,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал		68,762,384.80	83,017,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		101,690,495.66	115,860,765.65
210301	Гэрэл, цахилгаан		29,824,346.17	44,583,497.59
210302	Түлш, халаалт		60,270,981.99	56,945,967.14
210303	Цэвэр, бохир ус		11,595,167.50	14,331,300.92
2104	Хангамж, бараа материалын зардал		201,262,286.03	373,301,036.42
210401	Бичиг хэрэг		24,448,670.00	59,258,740.00
210402	Тээвэр, шатахуун		129,939,605.03	145,009,052.24

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын Хураангуй тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		740,121.00	1,003,154.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		45,653,890.00	29,678,392.00
210408	Бараа материал акталсны зардал		00.00	138,351,698.18
2105	Нормативт зардал		224,552,074.00	1,350,378,378.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		4,125,800.00	421,150.00
210502	Хоол, хүнс		212,413,520.00	273,349,048.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		8,012,754.00	1,076,608,180.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		89,937,666.60	75,329,176.00
210604	Урсгал засвар		89,937,666.60	75,329,176.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		41,465,066.00	137,690,967.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		35,367,000.00	127,166,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		2,144,966.00	7,156,318.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		467,400.00	119,600.00
210807	Газрын төлбөр		3,251,100.00	3,248,929.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,026,720,375.23	1,081,422,777.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,016,620.00	2,375,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		1,020,703,755.23	1,079,047,777.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		33,763,892.62	18,147,577.35
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,935,000.00	4,150,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		00.00	3,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,935,000.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		24,828,892.62	13,997,577.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		24,828,892.62	13,997,577.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		308,583,624.96	-372,193,236.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		308,583,624.96	-372,193,236.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,118,673,414.40	5,012,183,513.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,118,673,414.40	5,012,183,513.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,892,071,700.00	4,568,526,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,892,071,700.00	4,568,526,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	226,601,714.40	443,657,013.00

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын Хураангуй тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,857,420.00	49,954,020.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,062,000.00	50,828,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	146,682,294.40	342,874,993.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,094,573,414.40</u>	<u>5,012,183,513.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,094,573,414.40	5,012,183,513.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,056,776,421.78	4,985,491,935.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,437,353,191.41	4,067,812,100.00
210101	Үндсэн цалин	2,238,543,431.41	2,512,767,700.00
210102	Нэмэгдэл	995,054,660.00	1,373,492,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,646,500.00	23,473,400.00
210104	Урамшуулал	178,108,600.00	158,078,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,703,300.00	98,116,300.00
210201	Тэтгэврийн даатгал	4,489,400.00	9,094,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	528,100.00	551,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	263,800.00	282,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	263,900.00	5,170,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	69,158,100.00	83,017,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,293,738.97	103,579,891.65
210301	Гэрэл, цахилгаан	28,415,157.48	38,161,500.00
210302	Түлш, халаалт	66,283,413.99	51,087,090.73
210303	Цэвэр, бохир ус	11,595,167.50	14,331,300.92
2104	Хангамж, бараа материалын зардал	5,404,321.00	25,146,428.00
210401	Бичиг хэрэг	1,074,300.00	6,797,750.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	12,566,324.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	740,121.00	795,454.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,109,900.00	4,986,900.00
2105	Нормативт зардал	143,426,800.00	231,060,600.00
210502	Хоол, хүнс	143,426,800.00	231,060,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,996,390.00	135,936,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	72,405,000.00
210604	Урсгал засвар	51,996,390.00	63,531,500.00
2107	Томилолт, зочны зардал	12,085,039.40	00.00
210701	Гадаад албан томилолт	12,085,039.40	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,503,266.00	204,384,247.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,405,200.00	193,651,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,144,966.00	7,156,318.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	234,600.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	467,400.00	327,300.00
210807	Газрын төлбөр	3,251,100.00	3,248,929.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,010,375.00	119,455,869.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,010,375.00	116,455,869.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,796,992.62	26,691,577.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,968,100.00	12,694,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	12,294,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,968,100.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,828,892.62	13,997,577.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,828,892.62	13,997,577.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>24,100,000.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,100,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,100,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,100,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,100,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-24,100,000.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,067,222.28	826,665,473.84	6,848,501,247.91	9,080,233,944.03
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	308,583,624.96	308,583,624.96
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,067,222.28	826,665,473.84	7,157,084,872.87	9,388,817,568.99
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-372,193,236.28	-372,193,236.28
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,067,222.28	826,665,473.84	6,784,891,636.59	9,016,624,332.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын Хураангуй тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,577,784,400.00	4,560,667,722.65	17,116,677.35	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,577,784,400.00	4,560,667,722.65	17,116,677.35	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,565,489,000.00	4,548,373,722.65	17,115,277.35	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,067,812,100.00	4,067,812,100.00	-	100.0
210101	Үндсэн цалин	2,512,767,600.00	2,512,767,700.00	(100.00)	100.0
210102	Нэмэгдэл	1,373,492,800.00	1,373,492,800.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,473,400.00	23,473,400.00	-	100.0
210104	Урамшуулал	158,078,300.00	158,078,200.00	100.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,116,600.00	98,116,300.00	300.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	17,934,200.00	9,094,200.00	8,840,000.00	50.7
210202	Тэтгэмжийн даатгал	551,800.00	551,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	282,200.00	282,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,170,700.00	5,170,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	74,177,700.00	83,017,400.00	(8,839,700.00)	111.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,662,100.00	103,579,891.65	13,082,208.35	88.8
210301	Гэрэл, цахилгаан	38,161,500.00	38,161,500.00	-	100.0
210302	Түлш, халаалт	59,815,700.00	51,087,090.73	8,728,609.27	85.4
210303	Цэвэр, бохир ус	18,684,900.00	14,331,300.92	4,353,599.08	76.7
2104	Хангамж, бараа материалын зардал	7,571,200.00	5,927,104.00	1,644,096.00	78.3
210401	Бичиг хэрэг	1,245,900.00	894,750.00	351,150.00	71.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,088,400.00	795,454.00	1,292,946.00	38.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,236,900.00	4,236,900.00	-	100.0
2105	Нормативт зардал	177,654,600.00	177,444,600.00	210,000.00	99.9
210502	Хоол, хүнс	177,654,600.00	177,444,600.00	210,000.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,531,500.00	63,531,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	63,531,500.00	63,531,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	31,800,900.00	31,412,227.00	388,673.00	98.8

	үйлчилгээний төлбөр, хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,680,000.00	20,679,680.00	320.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,278,900.00	7,156,318.00	122,582.00	98.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	357,400.00	327,300.00	30,100.00	91.6
210807	Газрын төлбөр	3,251,100.00	3,248,929.00	2,171.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,340,000.00	550,000.00	1,790,000.00	23.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,340,000.00	550,000.00	1,790,000.00	23.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,295,400.00	12,294,000.00	1,400.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,295,400.00	12,294,000.00	1,400.00	100.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	12,295,400.00	12,294,000.00	1,400.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,577,784,400.00	4,568,526,500.00	9,257,900.00	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,577,784,400.00	4,568,526,500.00	9,257,900.00	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,577,784,400.00	4,568,526,500.00	9,257,900.00	99.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	154.00	154.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	150.00	150.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	437,518,213.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,518,213.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,118,213.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,219,324.00
210401	Бичиг хэрэг	5,903,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,566,324.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	750,000.00
2105	Нормативт зардал	53,616,000.00
210502	Хоол, хүнс	53,616,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,405,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	72,405,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,972,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,972,020.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,905,869.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,905,869.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	443,657,013.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	443,657,013.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,954,020.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,828,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	342,874,993.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “..гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах” гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь үйл ажиллагааны зорилгоо: “Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлж, дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг чанаржуулах;
- Дэвшилтэт технологи, шинэ санал, санаачилгыг дэмжих, нэвтрүүлэх;
- Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
- Тогтвортой хөгжлийг дэмжих, эдийг засгийг чадавхжуулах.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 2,997,855.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өглөө.

5. Дараагийн аудитаар анхаарах асуудал:

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулах журмыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчид шагнал олгох” журамд нийцүүлэн баталж мөрдүүлээгүй байна.

6. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,893,357.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,893,357.6 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитаар нийт 224,676.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,305.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 189,144.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 34,227.1 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 224,676.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 151,090.6 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тооцоолсон цалин хөлс, нэмэгдэл цалин, суутгалын дүнг анхан шатны баримт, ерөнхий журналтай тулгахад дансны бичилт алдаатай, урьдчилгаа цалин дансанд бүртгээгүй, НДШ, ХХОАТ-ын тайлан журналын бичилт цалингийн хүснэгтээс 1,844,083.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	1,844,083.8			1	1,844,083.8	1	1,844,083.8				
Нэмэлт санхүүжилтээс худалдан авсан 19,950.0 мянган төгрөгийн "Зөөврийн байр сууц" хөрөнгийн ангилал буруу, "Эрсдэлийн үнэлгээний эмхтгэл" 17,000.0 мянган төгрөгийн 43 ширхэг номыг бөөн дүнгээр, 1 ширхэгээр тоо хэмжээг зөрүүтэй бүртгэсэн байна.	1	36,950.0			1	36,950.0	1	36,950.0				
Өмнөх оны урьдчилж төлсөн зардал 12,280.8 мянган төгрөгийг, тайлант оны байр ашиглалтын зардалд хааж төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай илэрхийлсэн байна.	1	12,280.8			1	12,280.8	1	12,280.8				
Санхүүгийн байдлын тайланд үр дүнг 43.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.	1	43.0			1	43.0	1	43.0				
Дүн	4	1,893,357.6			4	1,893,357.6	4	1,893,357.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хэлтсийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төрийн Аудитын байгууллагад хүргүүлэх хуулийн хугацаанаас 12 өдрөөр хоцроон,цаасаар болон цахимаар ирүүлсэн санхүүгийн тайлан журнал дэлгэрэнгүй бүртгэлийн мэдээлэл алдаатай бүрэн бус байна.	1	-					1	-				
Бүрдэн Цохиот ХХК-тай гэрээ байгуулж, худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давуулж 174,920.1 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.	1	174,920.1			1	174,920.1						
Тусгай зориулалтын автомашины шатахууны нормыг тулган баталгаажуулахад ОБЕГ-ын баталсан нормоос 5,886.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн илүү, 19,046.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан зөрүү гарч байна.	1	24,933.1					1	24,933.1				
Гэрээгээр гүйцэтгэж байгаа бараа, ажил үйлчилгээний зарцуулалтанд илтгэх хуудасгүй, гэрээ дүгнэсэн актгүй, төсөв хөрөнгө зарцуулах тооцоололгүй зэрэг бүрдэл дутуу анхан шатны баримтаар 142,240.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж, зардалд тооцсон байна.	1	14,224.0			1	14,224.0						
Оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулсан шийдвэр нь эрх зүйн тогтоосон хувь хэмжээнээс үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж 8,010.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	1	8,010.0					1	8,010.0				
Эд хариуцагчийн хувийн дансанд 1,305.0 мянган төгрөгийг шилжүүлэн кассын тайлан хөтлөөгүй, алба хаагчдад олгосон жагсаалтгүй, гарын үсэггүй, нотлох баримтгүй зарцуулсан байна.	1	1,305.0	1	1,305.0								
Жилийн эцсийн тооллогын тооцоо бодсон актгүй, хөрөнгө ашиглалтын эд хариуцагчийн карт бүрэн бус, түлш шатахууны тайлан, зарлагын баримт шаардах хуудас болон замын тооцооны хуудсыг хянан баталгаажуулаагүй, авсан олгосон	1	-					1	-				

**Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
Хураангуй тайлан**

эд хариуцагчийн гарын үсэггүй, дотоод хяналт хангалтгүй байна.												
Төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан 1,284.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна.	1	1,284.0					1	1,284.0				
Дүн	8	224,676.2	1	1,305.0	2	189,144.1	5	34,227.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цахим дэлгүүрт байршсан 249,346.1 мянган төгрөгийн бараа, мах, хүнсний ногоог бусад этгээдээс худалдан авсан байна.	1	249,346.1			1	249,346.1		
Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,664,380.2 мянган төгрөгийн 31 гүйлгээ, зарлагын 84,129.0 мянган төгрөгийн 35 гүйлгээ, өмч, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 18 шийдвэр, нийт 2,748,509.2 мянган төгрөг байна.	1	2,748,509.2			1	2,748,509.2		
Нийт дүн	2	2,997,855.3			2	2,997,855.3		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 10/А0270181

Улаанбаатар хот

НТАГ-2028/558/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алба хаагчдад олгох хоолны мөнгө 1,305,000.00 (нэг сая гурван зуун таван мянга) төгрөгийг няравын хувийн дансанд шилжүүлэн кассын тайлан хөтлөөгүй, олгосон жагсаалтгүй, гарын үсэггүй зэрэг анхан шатны баримтгүйгээр зардалд тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, зохиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зэрчсэн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Эд хариуцагч П.Эрдэнэчимэгийн хувийн дансанд шилжүүлсэн 1,305,000.00 (нэг сая гурван зуун таван мянга) төгрөгийг нөхөн төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ. хүү торгуулийн орлогын МN440090 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

1426110924

2.Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга Д.Мөнхсайхан, ахлах нягтлан бодогч Г.Баярцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР



Б.ТЭГШЛХАМ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 50/А0270181

Улаанбаатар хот

НТАГ-2026/558/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сонгон шалгарсан "Бүрдэн Цохиот" ХХК-тай гэрээ байгуулж, худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давуулж 174,920,100.00 (нэг зуун далан дөрвөн сая есөн зуун хорин мянга нэг зуу) төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.12-т "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

1429990114

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга (Д.Мөнхсайхан), ахлах нягтлан бодогч (Г.Баярцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Б.ТЭГШЛХАМ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 49/АДЭТ/181

Улаанбаатар хот

НТАГ-2026/558/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтаар баталгаажуулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй, илтгэх хуудасгүй, зарцуулах төсвийн тооцоололгүй зэрэг бүрдэл дутуу 14,224,000.00 (арван дөрвөн сая хоёр зуун хорин дөрвөн мянга) төгрөгийн ажил, гүйлгээ бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга (Д.Мөнхсайхан), ахлах нягтлан бодогч (Г.Баярцэцэг) нарт даалгав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Г.НАНДИНЖАРГАЛ
Б.ТЭГШЛХАМ

1429990116



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 48/А0270181

Улаанбаатар хот

НТАГ-2026/558/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авч, 249,346.100.00 (хоёр зуун дөчин есэн сая гурван зуун дөчин зургаан мянга нэг зуун) төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга (Д.Мөнхсайхан), ахлах нягтлан бодогч (Г.Баярцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР

Б.ТЭГШЛХАМ



1429790117



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 49/А2240181

Улаанбаатар хот

НТАГ-2026/558/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,664,380,200.00 төгрөгийн 31 гүйлгээ, зарлагын 84,129,000.00 төгрөгийн 35 гүйлгээ, өмч, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 18 шийдвэр, нийт 2,748,509,200.00 (хоёр тэрбум долоон зуун дөчин найман сая таван зуун есэн мянга хоёр зуу) төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга (Д.Мөнхсайхан), ахлах нягтлан бодогч (Г.Баярцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Б.ТЭГШЛХАМ

1429790119